

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/05/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Ц.Аззаяа

Утас: 70432545

цахим хаяг: azzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Contents

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
4. Аудитын илрүүлэлт.....	11
4.1 Залруулсан алдаа.....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ҮЕНЧ БОДОНЧ БУЛГАН ГОЛЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Б.БАТЗОРИГ ТАНАА

2022.02.10 № 217
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үенч Бодонч Булган голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үенч Бодонч Булган голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЦЭГСҮРЭН



021020150

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1110000.0</u>	<u>4544900.0</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	1110000.0	4544900.0
354	Хангамжийн материал	1110000.0	4544900.0
35420	Аж ахуйн материал	1110000.0	4544900.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5059506.0</u>	<u>11460502.0</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5059506.0	11460502.0
392	Биет хөрөнгө	5059506.0	11460502.0
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1959500.0	2559500.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-326583.4	-1163083.5
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	15099370.0	20619170.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-15099370.0	-16123099.7
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8637262.3	11717262.3
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5210672.9	-6149247.2
39301	Програм хангамж	48125.0	48125.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-48125.0	-48125.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>6169506.0</u>	<u>16005402.0</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>10000.0</u>	<u>0.0</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10000.0	0.0
413	Өглөг	10000.0	0.0
4136	Бусад өглөг	10000.0	0.0
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	10000.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>6159506.0</u>	<u>16005402.0</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	6159506.0	16005402.0
512	Хуримтлагдсан үр дүн	6159506.0	16005402.0
51210	Өмнөх үеийн үр дүн	6159506.0	6159506.0
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	9845896.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>6169506.0</u>	<u>16005402.0</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	163,727,383.0	161,460,437.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>1,959,500.0</u>	<u>10,867,637.0</u>
120	Нийтлэг татварын бус орлого	1,959,500.0	10,867,637.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,959,500.0	10,867,637.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,959,500.0	10,867,637.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>161,767,883.0</u>	<u>150,592,800.0</u>

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	160,703,597.0	150,592,800.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	152,966,600.0	150,592,800.0
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,736,997.0	00.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	714,286.0	00.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	714,286.0	00.0
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	350,000.0	00.0
1330	Төсвийн захирагчдаас	350,000.0	00.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	163,462,487.8	151,614,541.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	163,462,487.8	151,614,541.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	144,565,689.4	141,683,340.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	105,832,858.8	113,108,578.1
210101	Үндсэн цалин	105,832,858.8	113,108,578.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,229,106.9	14,629,713.0
210201	Тэтгэврийн даатгал	8,995,789.9	10,173,030.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,058,331.0	1,063,074.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	846,662.0	904,963.0
210204	Ажилгүйдлийн даатгал	211,669.0	226,241.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,116,655.0	2,262,405.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,956,633.0	2,634,963.0
210301	Гэрэл, цахилгаан	295,533.0	239,963.0
210302	Түлш, халаалт	2,661,100.0	2,395,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	13,006,483.0	5,787,460.0
210401	Бичиг хэрэг	461,700.0	256,400.0
210402	Тээвэр, шатахуун	9,248,783.0	3,213,300.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.0	1,980,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,296,000.0	337,760.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,106,490.0	1,050,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,960,900.0	693,600.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	145,590.0	356,400.0
2107	Томилолт, зочны зардал	2,295,850.0	1,724,345.0
210702	Дотоод албан томилолт	2,295,850.0	1,724,345.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	589,300.0	712,500.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.0	297,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	69,300.0	69,300.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45,700.0	77,700.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.0	18,500.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	258,300.0	250,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,548,967.6	2,035,781.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	283,810.0	224,040.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,265,157.6	1,811,741.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,896,798.5	9,931,201.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,896,798.5	9,931,201.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,896,798.5	9,931,201.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	264,895.2	9,845,896.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	264,895.2	9,845,896.0

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	5,894,610.8	5,894,610.8
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,894,610.8	5,894,610.8
C07	Тайлант үеийн үр дүн	264,895.2	264,895.2
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,159,506.0	6,159,506.0
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,159,506.0	6,159,506.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,159,506.0	6,159,506.0
D08	Тайлант үеийн үр дүн	9,845,896.0	9,845,896.0
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,005,402.0	16,005,402.0

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	161767883.0	150592800.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	161767883.0	150592800.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	160703597.0	150592800.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	152966600.0	150592800.0
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	7736997.0	0.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	714286.0	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	714286.0	0.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	350000.0	0.0
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	350000.0	0.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	161767883.0	150592800.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	161767883.0	150592800.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	142871084.6	140661599.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	92372018.6	101315891.1
210101	Үндсэн цалин	62508268.0	71475297.0
210102	Нэмэгдэл	26041350.5	26018194.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3822400.0	3822400.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14722300.0	14722200.0
210201	Тэтгэврийн даатгал	10360000.0	10360100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1090600.0	1090500.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	872400.0	872400.0
210204	Ажилгүйдлийн даатгал	218200.0	218100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2181100.0	2181100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2956633.0	2634963.0
210301	Гэрэл, цахилгаан	295533.0	239963.0
210302	Түлш, халаалт	2661100.0	2395000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	12337583.0	6135400.0

210401	Бичиг хэрэг	301700.0	256400.0
210402	Тээвэр, шатахуун	9248783.0	3213300.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2000000.0	2000000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	787100.0	665700.0
2105	Нормативт зардал	285100.0	285100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	285100.0	285100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5317300.0	1125100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	4960900.0	768700.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	356400.0	356400.0
2107	Томилолт, зочны зардал	2295850.0	1724345.0
210702	Дотоод албан томилолт	2295850.0	1724345.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12291200.0	12425500.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11710200.0	11710200.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216000.0	297000.0
210803	Даатгалын үйлчилгээ	69300.0	69300.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45700.0	79200.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.0	19800.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250000.0	250000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	293100.0	293100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	293100.0	293100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18896798.5	9931201.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18896798.5	9931201.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18896798.5	9931201.0
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.0	0.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	150,592,800.0	140,661,599.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	150,592,800.0	140,661,599.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	150,592,800.0	140,661,599.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	109,053,400.0	101,315,891.1
210101	Үндсэн цалин	79,054,900.0	71,475,297.0
210102	Нэмэгдэл	26,176,100.0	26,018,194.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,822,400.0	3,822,400.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,722,200.0	14,722,200.0
210201	Тэтгэврийн даатгал	10,360,100.0	10,360,100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,090,500.0	1,090,500.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	872,400.0	872,400.0

210204	Ажилгүйдлийн даатгал	218,100.0	218,100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,181,100.0	2,181,100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,815,000.0	2,634,963.0
210301	Гэрэл, цахилгаан	520,000.0	239,963.0
210302	Түлш, халаалт	2,395,000.0	2,395,000.0
210304	Байрны түрээс	900,000.0	00.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,135,400.0	6,135,400.0
210401	Бичиг хэрэг	256,400.0	256,400.0
210402	Тээвэр, шатахуун	3,213,300.0	3,213,300.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.0	2,000,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	665,700.0	665,700.0
2105	Нормативт зардал	285,100.0	285,100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	285,100.0	285,100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,125,100.0	1,125,100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	768,700.0	768,700.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	356,400.0	356,400.0
2107	Томилолт, зочны зардал	2,738,000.0	1,724,345.0
210702	Дотоод албан томилолт	2,738,000.0	1,724,345.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,425,500.0	12,425,500.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,710,200.0	11,710,200.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	297,000.0	297,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	69,300.0	69,300.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.0	79,200.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.0	19,800.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.0	250,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	293,100.0	293,100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	293,100.0	293,100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	150,592,800.0	140,661,599.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	150,592,800.0	140,661,599.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	150,592,800.0	140,661,599.1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12.0	11.0
620001	Удирдах ажилтан	01.0	01.0
620002	Гүйцэтгэх ажилтан	08.0	07.0
620003	Үйлчлэх ажилтан	03.0	03.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал

татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Ц.Азжаяа 2022 оны 01 дүгээр сарын 13-наас 2021 оны 02 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргаа нь “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон усны зохистой ашиглалт, хамгаалалтыг бий болгох замаар сав газрын нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах” гэсэн зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Сав газрын хэмжээнд усны нөөцийн хомсдол, бохирдохоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

БОАЖЯ-ны дотоод аудитын хэлтсээс 2021 хяналт шинжилгээ үнэлгээ хийгдээгүй бөгөөд Ховд аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. Үнэлгээгээр 88.5%-тай үнэлэгдсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 161.4 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 1.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1.2 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9.0 сая төгрөгөөр буюу 249 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 4.5 сая төгрөг болж 3.4 сая төгрөгөөр буюу хандиваар ирсэн аж ахуйн материалын үлдэгдлээр өссөн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 8.5 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 3.4 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 8.5 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 4.5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 25.7 төгрөг, оны эцэст 34.9 сая төгрөг болж 9.2 сая төгрөгөөр өссөн нь сумын ОНХС-аас тавилга, тоног төхөөрөмж, хандиваар тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, өөрийн хөрөнгөөр тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой байна.

Тайлант онд 0.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 8.4 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, акталсан хөрөнгө байхгүй ба тайлант оны эцэст 11.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 6.2 сая төгрөг байсан оны эцэст 16.0 сая төгрөг болж тайлант онд 9.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 9.8 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргааны 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 150.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 150.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 150.6 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 150.6 сая төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 140.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 140.7 сая төгрөгийг зарцуулж 9.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 140.7 мянган төгрөг буюу 93.4 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшил 7.7 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1.2 сая төгрөгөөр, томилолтын зардлыг 1.0 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар орлого зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс 149 мэдээллийг хугацаандаа оруулсан, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 12 ажил гүйлгээг шилэн дансны сайтад байршуулаагүй байсныг нөхөж мэдээлүүлж залруулсан болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдаж, алдаа зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэлийг тулган хянах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0.8 сая төгрөгийн 1 алдаа зөрчил илэрснийг санхүүгийн тайланд залрууллаа.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд: Байгууллагын төсвөөс худалдан авсан 0.8 сая төгрөгийн өнгөт принтерийг үндсэн хөрөнгөд орлого авч тайлагнаагүй байсныг залрууллаа.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 0.8 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан 2022 оны 02 дугаар сарын 10-ны 10 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргаа	1	0.8	1	0.8	0	0	0	0	0	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Ц.АЗЗАЯА